



**ХЭНТИЙ АЙМГИЙН ЖАРГАЛТХААН СУМЫН
ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2025 оны 09 сарын 26 өдөр

Дугаар А/17

Жаргалтхаан сум

Хөрөнгө бүртгэж авах тухай

Монгол Улсын Боловсролын ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.3.1 дэх заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.1, 14.2.2 дахь заалт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн 4 дүгээр тогтоолын 4.1.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар барьж ашиглалтад оруулсан 320 хүүхдийн сургуулийн барилгыг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2024 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн 583 дугаар тогтоолоор олгогдсон зөвшөөрөл, байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн 9 дүгээр сарын 17-ны өдрийн 2 дугаар хуралдааны шийдвэрийн дагуу үндсэн хөрөнгөд бүртгэж авсугай.

2. Уг барилгыг тогтоолд тусгагдсан 7735624163 (долоон тэрбум долоон зуун гучин таван сая зургаан зуун хорин дөрвөн мянга нэг зуун жаран гурав) төгрөгөөр үндсэн хөрөнгийн дансанд бүртгэж, тайланд тусгаж ажиллахыг нягтлан бодогч (Г.Урансүх), нярвын үүрэгт ажлыг хавсран гүйцэтгэгч (П.Энхбаяр) нарт үүрэг болгосугай.

**ЗАХИРЛЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ**

Д.ЧИНБАТ

D/Tushaal-2025

232501033